



**ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/21

Улаанбаатар хот

Сургалтанд хамруулах тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх заалт, “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 5.1.8 дахь заалт, “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын хөдөлмөрийн дотоод журмын 11.7, 13.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Э.Ариунтуяа, ахлах инженер бөгөөд холбоо дохилолын инженер Ц.Батдэлгэр нарыг 2017 оны 06 дугаар сарын 08-ны өдрөөс 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг дуустал Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Худалдааны яамны дэмжлэгтэйгээр Азийн орнуудын дунд зохион байгуулж буй “Хөгжиж буй улс орнуудад зориулагдсан дэлхий нийтийн даяарчлал болон эдийн засаг Хятадад” сэдэвт тэтгэлэгт сургалтанд тус тус суралцуулсугай.

2. Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Э.Ариунтуяа, ахлах инженер бөгөөд холбоо дохилолын инженер Ц.Батдэлгэр нарын сургалтанд хамрагдсан хугацааны цалинг батлагдсан төсвийн үндсэн цалингийн зардлаас санхүүжүүлэхийг Нягтлан бодогч /Б.Пүрэвсүрэн/-д зөвшөөрсүгэй.

3. Гадаад сургалтын тайланг ирснээс хойш 7 хоногийн дотор Даргын зөвлөлд танилцуулахыг тус тушаалын 2 дугаарт заасан ажилтнуудад тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /Д.Алтангэрэл/-д даалгасугай.

ДАРГА Х.ЭРДЭНЭБИЛЭГ



3150600092